



СҮХБААТАР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2016 оны 09 сарын 27 өдөр

Дугаар 51

Баруун-Урт

ХҮСЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Онгон сумын ИТХ-ын 2016 оны 08 дугаар сарын 31-ны өдрийн 28 тоот тогтоол, Онгон сумын Засаг даргын 2016 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 1/141 тоот албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаас ТОГТООХ нь:

Нэг. Онгон суманд хийгдэж буй нэгдсэн халаалт, цахилгаан эрчим хүч, газар доорх инженерийн шугам сүлжээг сайжруулах ажилд шаардагдах хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар гаргасан сумын ИТХ-ын 28 тоот тогтоолыг дэмжсүгэй.

Хоёр. Уг ажилд зарцуулахаар төлөвлөсөн 1.746.176.957 төгрөгийг 2017 оны улсын төсөвт суулгах ажлуудыг судалж, УИХ-ын гишүүн болон Засгийн газарт санал тавьж шийдвэрлүүлэх талаар санаачлага гаргаж ажиллахыг аймгийн Засаг дарга /З.Энхтөр/-д даалгасугай.

Гурав. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга /Ж.Жаргалсайхан/-д, Онгон сумын ИТХ-д даалгасугай.

ДАРГА  Б.ГАНСҮХ

